

## ГЕОЛОГИЙН САЛБАР

БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн тогтоолоор 1960 онд МУИС-ийн Газарзүйн салбарын 3-р ангиас шилжүүлэн авсан 13 оюутныг Геологийн 3-р анги болгож, мөн онд шинээр 1-р ангид 39 оюутан элсүүлж нийт 52 оюутан, нэг багштайгаар Геологийн салбарыг Байгалийн Ухааны Факультетийн бүрэлдэхүүнд хичээллүүлэн эхэлснээр энэ салбарын суурь тавигдсан юм.

1961 оны 1-р сард Геологийн тэнхим байгуулагдаж тэнхимийн эрхлэгчээр Ж.Дүгэрсүрэн, багшаар Р.Барсболд, Ж.Лхамсүрэн, ЗХУ-ын мэргэжилтэн К.М.Малкова, Ю.Ф.Пекун нар ажиллаж байв. Эхний үед зөвхөн ашигт малтмалын ордын эрэл зураглалын мэргэжлээр сургалт явуулж, анхны төгсөлт 1963 онд болж 13 инженер геологичдыг бэлтгэн гаргав. 1991 оноос МУИС-д Геологийн салбар дахин нээгдэж геологи, шатах ашигт малтмалын геологийн мэргэжлээр төгсөлт хийж өнгөрсөн хугацаанд 650 гаруй геологичдыг бэлтгэсэн болно.

1998 онд Газарзүй-Геологийн Факультет бие даан зохион байгуулагдаж, манай салбар түүний хоёр салбарын нь нэг нь болсон билээ. Одоо геологийн салбарт өдрийн болон эчнээ ангид 230 гаруй оюутан суралцаж 10 гаруй багш ажилтан ажиллаж байна. Үүнд: Геологийн салбарын анхны төгсөгч геологи-минералогийн ухааны доктор проф. С.Дашдаваа, геологи-минералогийн шинжлэх ухааны доктор, дэд проф Д.Бат-Эрдэнэ, Ж.Бямба, геологи-минералогийн ухааны доктор, дэд проф Я.Болд, А.Пэрлээ, геологи-минералогийн ухааны доктор Л.Жаргал, Д.Доржготов нарын эрдмийн зэрэг цолтой багш нар байна. Нийт багш нарын 67% нь эрдмийн зэрэг цолтой. Салбарын дэргэд геологийн орчин судлал, эрдэс ба чулуулаг судлал, геоструктур, палеонтологи-түүхэн геологи, ашигт малтмал, бүс нутгийн геологийн лаборатори, кабинетууд ажиллаж байна.

Геологийн салбар нь сургалтын төлөвлөгөөний дагуу сургалтын ажил явуулж ирсэн бөгөөд энэ мэргэжлийн онцлог байдалтай холбогдон хичээлийн ба үйлдвэрлэлийн дадлагыг онцгойлон анхаарч ирсэн юм. Анхны хичээлийн хээрийн дадлагыг 1961 онд Геологийн зураглалын хичээлээр Шарын голын Өрмөгтэй уулын районд эхэлж дараагийн хэд хэдэн дадлага энэ районд хийгдсэн юм. Мөн ерөнхий геологийн хичээлээр хийх экскурсийг геологийн төрөл бүрийн процессыг харуулж чадах чиглэлийг харгалзан Төв, Булган, Архангай, Өвөрхангай аймгийн нутгийг сонгон авч одоо хүртэл энэ чиглэлээр хийж байна. Үйлдвэрлэлийн хээрийн дадлагыг геологийн төрөл бүрийн экспедици, үйлдвэрлэлийн анги,

салбаруудад оюутныг нэг бүрчлэн хувиарлах замаар хийж ирлээ. Мөн зарим гадаадын харилцаатай сургуулийн шугамаар Эрхүү, Ташкент, Герман улсын Фрайбергийн уул уурхайн академид хийж байсан бөгөөд одоо Бээжингийн Их Сургуулийн геологийн салбартай дадлага харилцан хийж байна. Энэ салбарын түүх нь ОХУ-ын ижил мэргэжлийн сургууль, тэнхимүүдтэй хамтын ажиллагааны салшгүй холбоотой бөгөөд салбарыг байгуулах, бэхжүүлэх, багшлах боловсон хүчин бэлтгэхэд хоёр улсын туршлагатай олон арван багш нар хамтран ажиллаж ирсэн билээ. Салбарын багш оюутнууд байгуулагдсан өдрөөсөө эхлэн эрдэм судлалын ажил хийж, Монгол улсын геологийн судалгаанд зохих хувь нэмэр оруулж ирсэн байна. 1973 оноос МУИС-ийн хэмжээнд анхны томоохон аж ахуйн гэрээт эрдэм шинжилгээний ажлыг эхлэн явуулж 10 гаруй жил гүйцэтгэж алт, нүүрс, ховор металлын орд газруудыг илрүүлэн нээж үнэлгээ өгсөн. Үүний зэрэгцээ проф С.Дашдаваагийн удирдлагаар Хэрлэнгийн олон улсын геологийн экспедицийг зохион байгуулж, Эрхүү хотын Их сургууль, Политехникийн дээд сургуультай (хуучнаар) хамтран ажиллаж Монголын геологи, ашигт малтмалын талаар судалгаа явуулж эрдэм шинжилгээний бүтээлүүдийг тогтмол гаргаж, судалгааны үр дүнгээр мэргэжлийн олон багш нар эрдмийн зэрэг хамгаалсан байна. Энэ экспедици нь цааш өргөжиж Хятад, Герман, Чех зэрэг улсуудын эрдэмтэд оролцож, Монголын геологи, ашигт малтмалын талаар судалгаа шинжилгээ явуулж, багш эрдэм шинжилгээний ажилтан геологичдийн мэргэжлийг дээшлүүлэхэд үр бүтээлтэй ажилласан байна. Одоо тус тэнхимийн залуу багш нар АНУ, Герман, Голланд улсад мэргэжил дээшлүүлж байна.

Тэнхимийн багш доктор Ж.Бямба, Д.Бат-Эрдэнэ, Д.Доржготов нар Монголын геологи, ашигт малтмалын зургуудын гол зохиогчид нь болсон юм. Салбарын багш, оюутнууд Монголын боржингийн геологи, геодинамик, хатуу ашигт малтмалын геологи, шороон орд бүрэлдэх структур геоморфологийн нөхцөл, сээр нуруутан амьтны палеонтологи, Монголын ховор металлын ордын геологи-гарал үүсэл зэрэг чиглэлүүдээр эрдэм судлалын ажил явуулдаг. Энэ хугацаанд геологийн салбар нь Эрхүүгийн Их сургууль, Техникийн Их Сургууль, Улаан-Үүд хотын геологийн хүрээлэн, Герман улсын Фрайберг хотын уул уурхайн академи, АНУ-ын Байгалийн түүхийн музей, Бээжингийн Их сургуулийн геологийн факультет зэрэг газруудтай сургалт эрдэм шинжилгээний талаар хамтран ажиллаж зохих үр дүнд хүрсэн байна. Тус салбарыг төгссөн геологич

инженерүүд Монгол орны нутагт зайлшгүй хийгдвэл зохих төрөл бүрийн масштабын геологийн зураглал, ашигт малтмалын эрэл үнэлгээ, ордын хайгуулын ажлыг шаардлагатай газар бүрт томилогдон очин ажиллаж, эх орныхоо эрдэс баялгийн судалгаанд дорвитой хувь нэмэр оруулж ажилласан юм. Тэдний дундаас төрийн шагналт геологич С.Цэрэн-Очир, Д.Гунгааням, В.Довжид, Д.Батбаяр аж үйлдвэрийн гавъяат ажилтан Д.Тогтох, Л.Мөнхтогоо, эрдэмтэн геологич Ч.Ээбум, Г.Дэжидмаа, Г.Бадарч геологийн албыг олон жил удирдаж үр бүтээлтэй ажилласан эрдэмтэн геологич Д.Чулуун, А.Баасанжав, Д.Санжаадорж нарын олон геологичдыг нэрлэж болно.



### **САМДАНГИЙН ДАШДАВАА** · Завхан аймгийн

Цагаанхайрхан суманд 1937 оны 10-р сарын 5-нд төрсөн. 1963 онд Монгол Улсын Их Сургуулийн геологийн салбарыг геологич-инженер мэргэжлээр төгссөн. 1963-1967 онуудад МУИС-д багш, 1967-1971 онуудад МУИС-д минералогич-петрографийн тэнхимийн эрхлэгч, 1971-1972 онуудад МУИС-ийн Геологи-Уул уурхайн Факультетийн декан, 1972-1982 онуудад Политехникийн дээд сургуулийн орлогч захирал, 1992-2001 онууд МУИС-д тэнхимийн

эрхлэгч, 2001 оноос МУИС-д багш, 1977 онд Украин улсын Киевийн шинжлэх ухааны Академийн Геохими-минералогийн хүрээлэнд Их-хайрханы вольфрамитын ордын геологи-гарал үүслийн онцлог сэдвээр геологи-минералогийн ухааны докторын зэрэг хамгаалсан. 1982 онд дэд профессор, 1993 онд профессор цол хүртсэн. Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одон, Алтангадас одон, хөдөлмөрийн хүндэт медаль, Зэвсэгт хүчний 60 жилийн ойн медаль, Ардын хувьсгалын 70, 80 жилийн ойн медаль, Боловсролын тэргүүний ажилтан, Шинжлэх ухааны тэргүүний ажилтан, Тэргүүний геологич, Тэргүүний уурхайчин, Тэргүүний халамжлан хүмүүжүүлэгч, Монголын үйлдвэрчний эвлэлийн Тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнагдсан. Удирдсан докторант-2, магистрант-5, бичсэн ном сурах бичиг гарын авлага-16, эрдэм шинжилгээний өгүүлэл-68, үйлдвэрлэлд шилжүүлсэн тайлан төсөл-10. Эдгээрийн дотроос Эрдэс чулуулаг, Эрдэс чулуулаг судлал, Геологи-минералогийн үндэс, Геологийн үндсүүд, Металл ашигт малтмалын орд, Кристаллографи ба кристаллохими, Жанчивлангийн районы структур

хүдэржилтийн онцлог зэрэг сурах бичиг, нэг сэдэвт зохиол гарын авлагууд бичсэн болно.



### **ЛУВСАНЧҮЛТЭМИЙН ЖАРГАЛ** Улаанбаатар

хотод 1957 оны 11 сарын 9-нд төрсөн. 1980 онд МУИС-ийн ашигт малтмалын ордын эрэл хайгуулын геологич инженер мэргэжлээр төгссөн. 1980-1997 онуудад Геологийн төв лабораторид петрографийн инженер, хяналтын инженер, 1998 оноос МУИС-д багш, 2001 оноос тэнхимийн эрхлэгчээр ажиллаж байна. 1997 онд Улаанбаатар хотод Дорнод Монголын доод цэрдийн нүүрсний петрографийн найрлага, чанар, хуримталсан нөхцөл сэдвээр геологи-минералогийн ухааны докторын зэрэг хамгаалсан. Тэргүүний геологичоор шагнагдсан. Удирдаж байгаа магистр-1. Сурах бичиг -1, монограф-1, гарын авлага-+2, эрдэм шинжилгээний өгүүлэл-30, үйлдвэрийн тайлан-4. Эрдэс чулуулаг судлал сурах бичиг бичсэн. Дорнод Монголын доод цэрдийн нүүрсний петрографийн найрлага, чанар, хуримталсан нөхцөл -монограф. Чулуулаг тодорхойлох микроскопын аргууд, Чулуулаг бүрдүүлэгч эрдсүүдийг тодорхойлох аргууд-гарын авлага бичсэн.



### **ЖАМБЫН БЯМБА** Баянхонгор аймгийн Богд

суманд 1940 оны 10-р сарын 15-нд төрсөн. 1965 онд ЗХУ-д Москвагийн геологи-хайгуулын дээд сургуулийг геологич мэргэжлээр төгссөн. 1972 онд геологи-минералогийн ухааны докторын зэргийг Хойд Монголын структур-фаацын бүс ба фосфорит агууламж сэдвээр, 1991 онд геологи-минералогийн шинжлэх ухааны докторын зэргийг Монголын  $PR_2$ - $PZ_1$  структурийн хөгжил ба эртний фосфоритийн үүсэн нөхцөл сэдвээр хамгаалсан. Тэргүүний геологич, Шинжлэх ухааны тэргүүний ажилтан, 50, 60, 80 жилийн ойн медалиудаар шагнагдсан. Удирдсан магистрант -2. Нэг сэдэвт зохиол 12-г бичсэн. Үүнд: сурах бичиг 2, монограф- , гарын авлага-3, эрдэм шинжилгээний өгүүлэл-81, үйлдвэрлэл, эрдэм шинжилгээний тайлан-4. Зарим зохиол: 1.Монголын эртний структур ба тэдгээрийн фосфорит агууламж (орос хэл дээр). 1996, 181х. 2.Тектоникийн үндэс. 1998, 81 х. 3.Далайн геологийн

тойм.1998, 104х. 4.Монгол орны эрдэс баялаг (Ц.Гүндсамбуугийн хамт) 1979, 161х.  
5.Монголын Хөвсгөлийн фосфоритийн сав (орос хэл дээр). 1980, 60 х.



**ДЭЛЭГИЙН БАТ-ЭРДЭНЭ** Ховд аймгийн Буянт суманд 1943 оны 10 дугаар сарын 29-нд төрсөн. Ховд аймгийн төвд 1962 онд 10 жилийн сургууль, ЗХУ-ын Эрхүү хотод 1967 онд Политехникийн дээд сургуулийг Уулын инженер-геологич-ийн мэргэжлээр төгссөн. Чойрын геологийн удирдах газарт 1968-1970 онд ангийн ахлах, ерөнхий инженер; ТЭХҮГЯ-нд 1971-1973 онд ахлах мэргэжилтэн; 1973-1976 онд ЗХУ, Эрхүүд ПДС-д аспирантурт; 1976-1977 онд ГУУУШИ-д ЭША; 1977-1978 онд СнЗ-д хэлтсийн дарга; 1978-1981 онд ТГУГ-т ангийн ерөнхий геологич, 1981-1993 онд ГУУУШИ-д секторын эрхлэгч; 1993-1997 онд Монгол газрын тос компанид ерөнхий геологич; 1997 оноос МУИС-д багш. ЗХУ, Эрхүү хотод 1978 онд геологи-минералогийн ухааны докторын зэргийг Нижнемеловые угленосные отложения Чойренской впадины (Вост.Монголия) сэдвээр ЗХУ, Москва хотод 1992 онд геологи-минералогийн шинжлэх ухааны докторын зэргийг Закономерности размещения и условия образования угольных бассейнов в орогенных структурах Монголии сэдвээр хамгаалсан.

Дэд профессорын цолыг 1998 онд авсан. 1971 онд Алтан гадас одон, 1971 онд МХЗЭ-ийн нэрэмжит тусгай шагнал, 1981 онд АХ-ын 60 жилийн ойн медаль, 1989 онд Тэргүүний геологич тэмдэг, 1991 онд Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одон, 1999 онд Шинжлэх ухааны тэргүүний ажилтан. Удирдсан аспирант-2, удирдсан магистрант 3, одоо удирдаж буй докторант-2, магистрант-1. Ном, сурах бичиг, гарын авлага-12, ЭШ-ний өгүүлэл, илтгэл-97, ЭШ-ний тайлан, үйлдвэрлэлийн тайлан, зөвлөмж, экспертизийн дүгнэлт-23. Үүнээс гол нь: Чойрын хотгорын доод цэрдийн нүүрстэй хурдас, 1976; Полезные ископаемые, УБ-М, 1990. Шатдаг занарын судалгааны нэр томъёоны тайлбар толь, М; 1992; Шатдаг занарын сорьцлолт, лабораторийн задлан шинжилгээний аргачлалын зөвлөмж, М., 1992; Монголын нүүрсний геологи. УБ, 2001; Шатах ашигт малтмалын геологи, УБ, 2000. Горючие полезные ископаемые Монголии. УБ, 2001. Монголын түлшний ашигт малтмалын судалгаа, үр дүн, УБ, 2001; Цикличность угленосных отложений Монголии. УБ, 2001; Монголын нүүрсний

петрографийн судалгаа, үр дүн. Уб, 2002; Нүүрсний чанарын үзүүлэлтийн цаг хугацаа, орон зайн өөрчлөлтийн зүй тогтол. Уб, 2002.



### **ЯДАМСҮРЭНГИЙН БОЛД** нь 1940 онд

Улаанбаатар хотод төрсөн. 1959 онд бүрэн дунд сургууль, 1966 онд МУИС-ийн геологийн салбарыг геологич-инженер мэргэжлээр төгссөнөөс хойш 36 жил ТИС, МУИС-д багшаар ажиллаж байна. 1985 онд Геологи минералогийн ухааны докторын зэрэг хамгаалсан. Ном, гарын авлага 14, эрдэм шинжилгээний өгүүлэлүүд 65, үйлдвэрлэлийн төсөл, тайлан 15, нийт 110 бүтээл хэвлүүлж эрдэс судлалын Декрептометр багаж зохиосноор ШБОС-ын 19193 тоот гэрчилгээг авч байсан ба 60, 70 жилийн ойн медалиуд, 1989 онд Тэргүүний геологич, 1992 онд Ардын боловсролын тэргүүний ажилтан цол, тэмдэг, дэд профессор цолоор, Шинжлэх ухааны тэргүүний ажилтан цол тэмдэгээр шагнагдсан.



### **АЛТАНГЭРЭЛИЙН ПЭРЛЭЭ** Төв аймгийн

Баянцагаан суманд 1945 оны 7 сарын 1-нд төрсөн. 1968 онд МУИС-ийн Геологийн салбарыг геологийн инженер мэргэжлээр, 1981-1984 онд биологичоор Москвагийн Улсын Их сургуулийг төгссөн. 1968-1969 онд Улаанбаатар хотын геологийн удирдах газарт инженер, 1969-1991 Монгол Улсын ШУА Геологийн хүрээлэнд Э/Ш-ний ажилтанаар, 1991-1994 онуудад Монгол Улсын Байгалийн Түүхийн Музейн захирал, Э/Ш-ний тэргүүлэх ажилтанаар, 1994 оноос одоо хүртэл МУИС-ийн геологи-минералогийн тэнхимд багш. Биологийн ухааны докторын зэргийг ЗХУ-ын Москва хотод 1991 онд хамгаалсан. Дэд профессорын цолыг 1996 онд хүртсэн. Монгол улсын тэргүүний геологич, Монгол Улсын шинжлэх ухааны тэргүүний ажилтан цол тэмдэгтэй, 70 жилийн ойн медальтай. 1 магистрын ажлыг удирдаж хамгаалуулсан. Байгалийн Түүхийн музейн захирлаар ажилласан 4 жилийг оролцуулахгүйгээр Эрдэм шинжилгээний байгууллага болон МУИС-д багшилсан нийт 30 жилийн дотор 70 гаруй эрдэм шинжилгээний бүтээл бичиж 30-г нь Орос, Англи, Канад, Польш, Америкийн шинжлэх ухааны хэвлэлүүдэд

хэвлүүлсэн байна. Үүнд: Далавчгүй шувууны үүслийн тухай-Английн Nature сэтгүүлд 1993, 1994 онуудад.

Монголын цэрдийн холимог идэшт динозавр-эрликозаврын ясан биеийн морфологи: Невроанатомийн асуудал 1994, 1995 онуудад Америкийн Science сэтгүүлд. Мөн далавчгүй шувуу динозавраас угшилтай болох талаар Америкийн Science сэтгүүлд. Зөвлөлтийн ШУА-ий академийн хэвлэл Палеонтологический журнал -д Динозаврын бүлгийг 3 төрөл, 3 зүйл амьтны хэмжээнд судлан тогтоож Дэлхийн динозавр судлалын каталогид холимог идэшт бүлэг динозаврыг анх нээсэн байна (Москва 1979., 1981, 1983). Мөн Польшийн Шинжлэх ухааны хэвлэл Paleontologica-д холимог идэшт, амфибионт динозаврын инфра отряд -Segnosauria-г анх бичиж хэвлүүлжээ. Америкийн хоёр судлаачийн хамт 1993, 1995 онд Канадын олон улсын сээр нуруутны палеонтологийн чуулга уулзалтад нисдэггүй шувууны гарал үүслийн асуудлаар илтгэж хэлэлцүүлсэн бүтээлээ Canadian journal of earth Sciences-т хэвлүүлсэн. Харин сүүлийн 8 жилийн дотор МУИС-д багшлах явцдаа өөрийн заадаг хичээлийн дагуу 1. Шим мандал дахь палеоэкологи, тафономын үндсэн асуудлууд, 2. Далайн сээр нуругүй амьтдын палеонтологи сурах бичиг, 3. Дэлхийн геологийн хөгжлийн түүхэн товчоон сурах бичиг бичиж хэвлүүлсэн байна. Мөн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын 4 тайлан, геологийн үйлдвэрлэлийн 2 тайлан, 1 төсөл бичиж хамгаалсан.



### ДАНГИНДОРЖИЙН ДОРЖГОТОВ Өвөрхангай

аймгийн Гучин суманд 1948 оны 7 сарын 15-нд төрсөн. Арвайхээр хотын 10 жилийн сургуулийг 1967 онд, МУИС-ийн Геологийн салбарыг 1974 онд төгссөн. ГУУҮЯ-ны харьяа Геофизик-Топозургийн экспедицид 1974-1976 онуудад эрлийн инженерээр, 1976-1996 онуудад Геологи-Эрдэс баялагийн хүрээлэнд ЭША, ахлах ажилтан, эрдэмтэн нарийн бичгийн даргаар, Монруд компани-д 1996-1998 онуудад эрлийн ангийн менежерээр, МУИС-ийн

геологийн салбарт 1999 оноос эхлэн багшаар ажиллаж байна. 1996 онд Дорнод Монголын мезозойн үеийн вулкан-плутон бүслүүрийн цайр-хартугалганы хүдэржилт сэдвээр докторын (Ph.D) зэрэг хамгаалсан. 2001 онд МУИС-ийн дэд профессор цол авсан. Монгол улсын тэргүүний геологич, YI, YII таван жилийн гавшгайч цол тэмдгээр шагнагдаж байсан. Магистрын ба бакалаврын ажил 10

гаруйг удирдаж хамгаалуулсан. Геологи, ашигт малтмалын чиглэлтэй сурах бичиг 3, ном товхимол 2, эрдэм шинжилгээний өгүүлэл 30 гаруй, тайлан 20 гаруйг, Монголын ашигт малтмал, металлогений 1:1000000-1:3000000- масштабтай 6 зураг зохиолцсон.



**БОЛДЫН БАТ** 1969 онд Улаанбаатар хотод төрсөн. 1991 онд ОХУ-ын Иркутск хотын Техникийн их сургуулийг гидрогеологич мэргэжлээр төгссөн. МУИС-ийн магистр зэрэгтэй. 1993 оноос МУИС-ийн геологийн салбарт багшаар ажиллаж байгаа. 1998-2000 онд ОХУ-ын Иркутск хотын Техникийн Их сургуульд аспирантурт суралцсан. 2001 оноос Голланд улсад магистрантурт суралцаж байна.



**НАМСРАЙН МӨНХБИЛЭГ** Улаанбаатар хотод 1974 оны 3-р сарын 14-нд төрсөн. 1981-1991 онд Улаанбаатар хотын 10 жилийн 1-р сургуулийг, 1991-1995 онд Монгол Улсын Их Сургуулийг геологич бакалавраар төгссөн. 1995-1997 онд МУИС-ийн магистрийн зэрэг авсан. 1995 оноос МУИС-ийн БУФ-ийн Геологийн салбарт цагийн багшаар, 1997 оноос МУИС-ийн ГГФ-ийн Геологи-Минералогийн тэнхимд багшаар ажиллаж байна. 1998 оноос МУИС-ийн Докторантурт суралцаж байгаа. Гарын авлага-1, өгүүлэл -2-ыг бичиж хэвлүүлсэн.



**БАЛДОРЖИЙН БААТАРЦОГТ** 1973 оны 9-р сарын 5-нд Улаанбаатар хотод төрсөн. 1982-1992 оны онд Улаанбаатар хотын 10 жилийн 56-р сургуулийг, 1993-1997 онд МУИС-ийн Геологийн салбарыг Геологич мэргэжлээр, 1994-1997 онд МУИС-ийн ОУХДС-ийн оройн сургуулийг Орчуулагч (Англи)-аар, 1997-1999 онд МУИС-ийн магистрантурт суралцаж төгссөн. Эрдэм шинжилгээний өгүүлэл -3-г бичиж хэвлүүлсэн.



**СОДНОМЫН ОЮУНГЭРЭЛ** 1975 оны 10 сарын 31-нд Улаанбаатар хотод төрсөн. 1993 онд 10 жилийн 31-р дунд сургуулийг, 1997 онд МУИС-ийн Геологийн салбарыг геологич мэргэжлээр төгссөн. 1999 оноос Геологи-Минералогийн тэнхимд багшаар ажиллаж байна. 1999 онд МУИС-д магистрын зэрэг хамгаалсан. Гарын авлага-2, Монограф-1, эрдэм шинжилгээний өгүүлэл-7-г бичиж хэвлүүлсэн.



**НОРОВЫН БАЙГАЛМАА** Баянхонгор аймагт төрсөн. Баянхонгор аймгийн 10 жилийн I сургуулийг төгссөн. 1993 онд МУИС-ийн БУФ-ийн Геологийн салбарын Газрын тосны ангид орж суралцаад 1997 онд ШАМ-ын геологич мэргэжлээр төгссөн. 1997-1999 онд МУИС-ийн магистрын зэрэг хамгаалсан. 2000 оноос МУИС-ийн докторантурт суралцаж байна. Эрдэм шинжилгээний өгүүлэл -4-г бичиж хэвлүүлсэн.



**СҮРБЭЭГИЙН МЯГМАРЖАВ** 1962 оны 9-р сарын 4-нд Говь-Алтай аймгийн Шарга суманд төрсөн. 1980 онд Говь-Алтай аймгийн I 10 жилийн сургуулийг, 1982 онд Завхан аймгийн худалдааны техникумыг эдийн засагч, нябогийн мэргэжлээр төгссөн. 1982-1984 онд Говь-Алтай аймгийн Шарга сумын ХБА-д эдийн засагч. 1985 онд аймгийн захиргаанд мэргэжилтэн, арбиторийн нарийн бичгээр, 1986 оноос Шарга сумын ХБА-д ня-бо-аар, 1997 оноос МУИС-ийн ГГФ-ийн Геологи-Минералогийн тэнхимд ажиллаж байна. Геологийн эчнээ ангид суралцдаг.



**БАТ-ОРШИХЫН ЭРДЭНЭЦОГТ** 1976 онд Улаанбаатар хотод төрсөн. 1998 онд ШАМ-ын геологич мэргэжлээр төгссөн. 1998-2000 онд МУИС-ийн магистрантурт суралцаж төгссөн. 2000 оноос МУИС-ийн докторантурт суралцаж байна. Эрдэм шинжилгээний өгүүлэл -1.